

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор уламжлал болгон зохион байгуулдаг “Хөх сувд-2019” мөсний баярын арга хэмжээ 3 сарын 2-3 өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Энэ жилийн “Хөх сувд” арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн нутгийн иргэдийн ахуй амьдралын онцлогийг харуулсан “НҮҮДЭЛ” сэдвийн хүрээнд мөсөн урлангуудаа хийснээрээ онцлог байв.

Хүүхэд хамгаалал-өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Өрхийн хөгжилд-эмэгтэйчүүдийн манлайлал” арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран “2019 оны 03 дугаар сарын 8-ны өдөр амжилттай зохион байгуулав. Тус арга хэмжээнд 24 сумын алдар гавьяатай болон зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн төлөөлөл, аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүд, төрийн албан хаагчид зэрэг нийт 300 эмэгтэй оролцлоо.

2019 оны 3 дугаар сарын 6-ны өдөр, Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Такаока болон Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд нар Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс- Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”-ийн хүрээнд “Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын цэцэрлэгийн өргөтгөлийн төсөл” болон “Хөвсгөл аймгийн Тариалан сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны засварын төсөл”-ийг хэрэгжүүлэх 2 гэрээнд гарын үсэг зурав.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017-2018 оны хэлэлцээрээ дүгнэж, 2019-2020 оны шинэ хэлэлцээрийг байгуулж, гарын үсэг зурах арга хэмжээг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. 2017-2018 оны хэлэлцээр 85,9% хэрэгжсэн бөгөөд хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд шинээр бий болсон байнгын ажлын байр нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин 6,5 пункт болж буурсан нь 2016 онтой харьцуулахад 2 пунктээр буурсан үр дүнтэй байна. Мөн иргэдийн хөдөлмөрлөх эрх, ажиллах орчин нөхцөл сайжирч, нийгмийн хамгааллын асуудалд дэвшил гарсан гэж талууд дүгнэсэн байна.

Хилчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг 2019 оны 3 дугаар сарын 4-нөөс 6-ны өдрүүдэд Хилийн 0257 дугаар ангиас аймгийн ГБХЗХГ, аймгийн ЭМГ-тай хамтран зохион байгуулж байна. Уг чуулга уулзалт жилд 2 удаа зохион байгуулагддаг ба 6 дахь жилдээ зохион байгуулагдаж, энэ жилийн арга хэмжээнд нийт хилийн засталаас 160 хилчин эмэгтэйчүүд оролцлоо.

Төрийн соёрхолт түүхч, Доктор Д.Өлзийбаатар Мөрөн хотноо зочилж “ТҮҮХЭН СУРГАМЖ, ОДОО БА ИРЭЭДҮЙ” лекцээ төрийн албан хаагчид, иргэд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад хүргэлээ.

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл Монгол улсын Төрийн албаны зөвлөлтэй хамтран төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор агентлаг байгууллагын дарга, хүний нөөцийн ажилтан, дотоод ажил хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд болон сумдын ЗДТГ-ын дарга, дотоод ажил эрхзүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд зориулсан шинээр батлагдан гарсан дүрэм журмуудын талаарх сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтанд аймгийн төрийн байгууллагын 270-д албан хаагч хамрагдаж төрийн албаны зөвлөлийн ахлах референт Г.Зоригтбаатар, ахлах референт Н.Амармэнд нар оролцож сургалт мэдээлэл хийж албан хаагчдын сонирхсон асуултанд хариулт өгч ажиллалаа.

Аймгийн Онцгой байдлын газраас байгууллага бүрт 1-5 албан хаагчдын өрөөнд зарлан мэдээллийн дуут дохио дамжуулах төхөөрөмжийг байршуулж, төхөөрөмж байрлуулах албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Мөн Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор жил бүрийн гуравдугаар сарын гурав дахь долоо хоногийн Пүрэв гарагийн 16:00 цагт орон даяар гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугарч энэ үеэр аймгийн хэмжээнд 161 аж ахуйн нэгж, байгууллагууд, 1693 албан хаагчид хамрагдсан байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцоо. 2019 оны 02 сарын байдлаар төрийн сангийн төлбөр тооцооны freebalance программаар нийт 42 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 12,546,210,075.10 сая төгрөгний 1,723 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн орлого. 2019 оны эхний 02 сарын байдлаар орон нутгийн орлого, санхүүжилт 4,625,619.1 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 4,097,182.2 сая төгрөг буюу 112.2% хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн зарлага. Нийт батлагдсан төсөв 18,506,425.20 мянган төгрөг байгаа бөгөөд үүний 8,690,609.3 мянган төгрөг нь ТЗШ-ээс, 8,719,055.2 мянган төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгогдох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлого, 37,979.5 мянган төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 426,473.0 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжсэн байна. 02 дугаар сарын 28-ний байдлаарх гүйцэтгэлээс харахад зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 18,506,425.20 мянган төгрөг буюу 97.5 %-тай, зарлагын гүйцэтгэл 18,039,065.0 мянган төгрөг буюу 99.2 %-тай байна.

Төсвийн өглөг авлага. 02 сарын байдлаар нийт авлага 184,019.2 мянган төгрөг өмнөх сараас 90,132.9 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт өглөг 1,033,579.6 сая төгрөг өмнөх сараас 307,988.0 сая төгрөг буурсан байна.

Гурав. Боловсрол, соёлын салбарын бодлогын хүрээнд:

Жайка төслийн баг “ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зүүлэх хөгжлийн дэмжлэгийг тогтолцоог бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих, сайжруулах нь” сургалтыг зохион байгуулж цэцэрлэгийн арга зүйч, багш, эмч нарыг хамрууллаа.

Аймгийн Засаг даргын ивээл дор аймгийн “Ахмад багш нарын холбоо”, аймгийн БСУГ хамтран ахмад багш нарын чуулганыг 2019 оны 3 сарын 20-нд зохион байгууллаа. Чуулганд Монгол улсын гавьяат багш нар, ахмад багш нар сургуулийн захиралууд оролцлоо

Аймгийн ЗДТГ, БСУГ-аас санаачлан аймгийн ХДТ-т ур чадварын түвшин тогтоох шалгалтыг 2019 оны 03 сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулж байна. Энэхүү шалгалтыг Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн сургуулийн захирал Г.Ганцэцэг /хөгжим судлаач, төгөлдөр хуурч, доктор/, Театрийн урлагийн сургуулийн жүжиглэх, найруулах урлагийн тэнхэмийн эрхлэгч М.Ариунжолоо, Бүжгийн урлагийн сургуулийн тэнхэмийн эрхлэгч С.Гэрэлтуяа, Хөгжмийн урлагийн сургуулийн уран сайхны удирдагч, хөгжмийн зохиолч Д.Ариунболд нар ажиллалаа.

"Дэлхийн Хөвсгөл" англи хэлний хөтөлбөрийг гадаад хэлийг мэдээлэл, харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл болгон хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа бөгөөд хэл сурах орчныг сайжруулах зорилтын хүрээнд “Гурван- Эрдэнэ” сургуульд 20 орчим сая төгрөгийн санхүүжилтээр лингафоны кабинет байгууллаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон аймгийн ИТТХ-аар аймгийн БСУГ-аас “Эх хэлбичиг”, “Оюунлаг Хөвсгөл”, “Цахим боловсрол”, “Дэлхийн Хөвсгөл” дэд хөтөлбөрүүдийн 2018 оны хэрэгжилт, үр дүнг танилцууллаа.

Аймгийн төрөлжсөн хичээлийн олимпиадууд явагдаж байна. Одоогоор нийгэм, газарзүй, математик, биологи, техник технологи, англи хэлний хичээлийн олимпиад зохион байгуулагдаж 1135 багш, сурагч оюун ухаанаа сорьлоо.

Соёлын төвүүдийн үйл ажиллагаа, нөхцөл байдлын судалгааг сумдаас авч нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг СУГазарт хүргүүлэв.

“Олон ястны өв соёл” хүүхдийн бага наадмыг аймгийн ГБХЗХГ-тай хамтран зохион байгууллаа.

Дөрөв. Эрүүл мэндийн бодлогын хүрээнд:

“Инээмсэглэл, эерэг хандлага”, “Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн төлөвлөгөөг мэргэжилтнүүдийн өгсөн саналын дагуу боловсруулж 4 чиглэлийн хүрээнд 28 үйл ажиллагааг төлөвлөн батлуулж, ЭМГ-ын даргын 260 дугаар албан бичгээр ЭМБ-дад цахимаар хүргүүлсэн ба “Хүүхэд хамгаалал -Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, уг арга хэмжээнд Хөвсгөл аймгийн удирдлагууд болон эрүүл мэндийн салбарын удирдлагууд, эмч, гэр бүл, хүүхдийн төлөөлөл бүхий 70 гаруй хүн оролцлоо.

“Эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах” тухай ЭМГ-ын даргын А/21 дүгээр тушаалыг боловсруулан гаргаж, тус тушаалаар сум, өрх, НЭ, ЭМГ, сумын

эрүүл мэндийн салбар зөвлөлийн хэрэгжүүлэх ажлын чиглэлийг боловсруулан, мөн эх% хүүхдийн тусламж үйлчилгээнд анхаарч ажиллах зөвлөмжүүд болон 2018 онд сум, өрх, НЭ-ийн харъяалалын 0-5 насны хүүхдийн эндэгдлийн тохиолдолд хийсэн Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эх, нярай хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх комиссоос ирүүлсэн зөвлөмжийг ЭМБ-уудад тус тус хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Архидан согтуурахтай тэмцэх салбар дундын хамтын оролцооны үүрэг” зөвлөгөөнийг Аймгийн ИТХ-ийн дэргэдэх ГХУСА33-тэй хамтран зохион байгуулсан ба уг зөвлөгөөнд 11 байгууллагын 22 төлөөлөгч оролцсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, эрүүл мэндийн сайдын А/485 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Геронтологийн үндэсний төвийн 3 хүний бүрэлдэхүүнтэй баг орон нутагт ирж “Настны эрүүл мэндийн стандарт, зааврыг танилцуулах” сургалтыг 2019 оны 03-р сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд ЭМГ-ын настны асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн нэгдсэн эмнэлгийн гериатрын их эмч, өрх сумдын эрүүл мэндийн төвийн дарга нар нийт 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд 2 өдрийн 2 багц цагийн сургалтанд хамрагдаж шинэ мэдээлэл авлаа.

ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн “Эмч нарын дэмжигч” нийгэмлэг, ДЗОУБ-тай хамтран, ЭМГ болон НЭ, сум өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эрүүл мэндийн судалгааны төсөл боловсруулах арга зүй” сургалт, “Инээмсэглэл-Эерэг хандлага” уриан дор эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны ур чадварт суралцах нь багц цагийн сургалт, “Мари стопс” ОУБ-тай хамтран Эх барих, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээний үндэсний стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, стандартыг таниулах зорилготой сургалтыг Хөвсгөл аймгийн бүх эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарт тус тус зохион байгууллаа. Мөн эмч мэргэжилтнүүдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, мэргэжлийн алдаа эрсдлээс урдчилан сэргийлэх зорилгоор Монголын Анагаах ухааны эрх зүйн холбооны тэргүүн, хүний их эмч, хуульч, өмгөөлөгч Э.Ганбатыг урьж “Анагаах ухааны эрх зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 320 эмч мэргэжилтнүүд хамрагдлаа.

Цэцэрлэг сумын ЭМТ-ийн эмч нарын үйлчлүүлэгчдэд үзүүлсэн тусламж үйлчилгээтэй холбоотой Цагдаагийн газраас ирүүлсэн мэдэгдлийн дагуу эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн эмнэлзүйн мэдлэгийг сэргээх, хууль эрх зүй, харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, Улсын 3 дугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төвүүдээс тархины цус харвалт, зүрхний шигдээс, гэмтэл согогийн тусламж үйлчилгээний өнөөгийн

байдал, хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгаа, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн өнөөгийн байдлын судалгааг гаргаж хүргүүлсэн.

ХХҮГ, ЭМГ-ын даргын хамтарсан удирдамжийн хүрээнд ӨЭМТ-үүдэд сүрьеэгийн илрүүлэг үзлэг, хооллолтын сургалтыг зохион байгуулах 1 сарын аяны үйл ажиллагааны нээлтийн арга хэмжээг хийж, 800 гаруй иргэдэд урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэг, ХӨ, ХБӨ-өөс сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийсэн ба өрхийн ЭМТ-үүдийн НЭМА-ууд даралт үзэх, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээг өртөөгөөр үзүүллээ. Уг аян ӨЭМТ-үүдэд түшиглэн үргэлжилж, одоогийн байдлаар эхний 3 өрхийн ЭМТ-д 1232 хүн хамрагдахаас 752 хүн буюу 61%-тай хамрагдаж байна. Мөн Ханх суманд элэгний В,С вирусийн ачаалал тоолох шинжилгээний баг ажиллаж 60 хүнийг ачаалал тоолох шинжилгээнд, 75 хүнийг илрүүлэг шинжилгээнд, 22 хүнийг үзлэгт хамруулж зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаа.

“Авьяас” сургуулийн ахлах ангийн 14 бүлгийн 359 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж 98,8 хувийг сургалтанд хамруулан зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. 100 хүүхдийг БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд хамруулсан ба өвчлөл илрээгүй. Давхардсан тоогоор нийт 390 хүүхдэд зөвлөгөө өгсөнөөс 120 хүүхдэд ганцаарчилсан, 270 хүүхдэд хэсэг бүлгийн зөвлөгөөг өгч хамтран ажиллаа.

Хилийн цэргийн 0232-р ангийн хилчин эмэгтэйчүүдийн сургалт зөвлөгөөнд “Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэг”, “ХБӨ-өөс сэргийлэх эрүүл дадалд суралцах мэдээллийн аяны мэдээлэл” сургалтыг хамтран зохион байгуулж, 200 гаруй эмэгтэйчүүд оролцсон. Мөн Алаг-Эрдэнэ, Цагаан-Уул сумдын 227 иргэн, 171 багш ажилчид, 490 гаруй сурагчид, ЭМБ-ын 59 ажилтан албан хаагчдад тус тус сургалт хийж мэдээллээр хангасан.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” 2 дугаар шатны арга хэмжээнд оролцох аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл, 21:100 хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жилд шинээр байгуулагдсан болон ажлын байр техник технологийн түвшинд өргөтгөл хийсэн үйлдвэрүүдийн судалгааг гаргаж ХХААХҮЯаманд, тайланг аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүллээ.

Цагаан-Уул суманд “Төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт” зохион байгуулж, ногоон тэжээл тариалах сэдвээр 350 гаруй төлөөлөгчдөд мэдээлэл хийлээ.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлэгт аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаа худалдан борлуулах,

үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэг салбар түүгээр худалдан борлуулагдаж буй согтууруулах ундааны тоо хэмжээ, нэг хүнд ноогдох согтууруулах ундааны хэмжээний талаархи судалгаа тооцооллыг танилцуулж, аймаг орон нутагт “Согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэх цэгийн норматив тогтоох журам” -ын төсөлд санал хүргүүллээ. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 471 дэлгүүр, тамхины тусгай зөвшөөрөлтэй 318 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.

“Хэрэглэгчийн өдөр” арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын аймаг дах орон тооны бус салбар зөвлөл, ХЭАХН, МХГ, Мөрөн сумын ЗДТГ-тай хамтран Шинэ-Мөрөн Худалдаа үйлчилгээний төв дээр “Хариуцлагатай хэрэглээ – Хэрэглэгчийн жил”-ийн хүрээнд “Аюулгүй ухаалаг бараа бүтээгдэхүүн” өдөрлөгийг зохион байгуулж, хэрэглэгчдэд мэдээлэл хүргэн хэрэглэгчийн эрхийн талаар мэдээлэл агуулсан гарын авлага 100 ширхэгийг хэвлүүлэн өдөрлөгт оролцогчдод олголоо.

Аймгийн ЗДТГ, БОАЖГ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Мөсний баяр – 2019” арга хэмжээний үеэр хүнсний аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгож зохистой хэрэглэх, өрхийн түвшинд давсны хэрэглээг бууруулах, худалдаа үйлчилгээний салбарт сав баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг хориглосон гялгар уутнаас татгалзахыг уриалсан гарын авлага нийт 4 төрлийн 100 гаруй гарын авлагыг иргэдэд түгээж жуулчдад зориулсан “Нүүдэлчидийн зоог” хоолны үзэсгэлэн арга хэмжээг аймгийн Тогоочдын холбоотой хамтран зохион байгууллаа.

Мал төллөлт, хаваржилтын мэдээг аймгийн ХХААГ дээр 7 хоног тутам нэгтгэж, ХХААХҮЯ-нд хүргүүлж байна. 2019 оны 3-р сарын 20-ны байдлаар 12212 толгой мал хорогдсноос 66 толгой мал халдваргүй өвчнөөр хорогдсон байна. Аймгийн дүнгээр 2545.6 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс 28945 хээлтэгч төллөж, 28821 төл бойжиж байна.

2019 онд аймгийн Мал хамгаалах сангаас мал төллөлт, хаваржилтийг хохирол багатай даван туулах зорилгоор аймгийн онцгой комиссын 2-р хуралдаанаар гарсан шийдвэрийн дагуу сумдад өвс, тэжээлийг хөнгөлттэй үнээр буюу үнэгүйгээр олгоход одоо байгаа өвс, тэжээлийн чанар байдалд үнэлгээ хийж, үнэгүйгээр 29 тн өвс, ногоон тэжээл- 40 тн, 2000 боодол өнжсөн өвсний үнийг 50, /3500 төг/, 1500 боодол өвсийг 50% /4500 төг/ 4000 боодол ногоон тэжээлийг 4500 төгрөг/, 12 тн хүчит тэжээлийг үнэгүйгээр, 58 тн хүчит тэжээлийг 25% ба /8000/ борлуулан тарааж эхлээд байна.

Аймгийн малын эмч мэргэжилтний анхдугаар зөвлөгөөн зохион байгуулж, 23 сум 1 тосгоны мал эмнэлгийн тасгийн 43 мэргэжилтэн, хувийн аж ахуйн нэгжийн 76 малын эмч хамрагдлаа.

Ховд аймагт зохион байгуулагдаж байгаа Зооноз, халдварт өвчин, тархвар зүй эпидемиологийн 7 хоногийн сургалтанд хариуцсан мэргэжилтнийг, Монголын мал эмнэлгийн холбооноос зохион байгуулсан аж ахуйн нэгжийн бага эмч нарт зориулсан “Итгэмжлэл олгох сургалт”-д 27 бага эмч нарыг тус тус хамрууллаа.

Аймгийн мал эмнэлгийн лабораторид давхардсан тоогоор 10 сумын 20 экспертизээр 56 дээжинд оношлогоо шинжилгээ хийгдэж, галзуу өвчний тохиолдол 1, листериоз өвчний тохиолдол 1 нийт 2 өвчний тохиолдол оношлогдож холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

.Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын хүрээнд:

Хөх сувд-2019” мөсний баярын арга хэмжээг 19 дахь жилдээ 2019 оны 3 дугаар сарын 2-4 –ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж гадаад, дотоодын 25000 гаруй зочид, төлөөлөгчид оролцож 16 төрлийн уралдаан, тэмцээн явагдаж иргэд идэвхтэй оролцлоо.

2019 онд Дэлхийн Усны өдрийг “Цэнгэг ус-тэгш хүртээмж” уриан дор байгаль орчны салбарын байгууллагууд хамтран 2019 оны 02 сарын 22-ноос 03 сарын 22-ны хооронд сарын аяныг дэлхийн усны өдрийг угтан зохион байгуулж байна. Ерөнхий боловсролын сургуулуудын дунд “Хөгжлөөс хэнч хоцрох ёсгүй” АХА тэмцээн, “Байгаль хамгаалах уламжлал” гар зургийн уралдаан, “Цэвэр ус- Цэгцтэй бодлого- хүн бүрийн оролцоо” эссэ бичлэгийн уралдааныг тус зохион байгуулж байна.

3-р сарын 01-нээс хэт нимгэн гялгар уутны хэрэглээг хориглохтой холбогдуулан Мөрөн сумын ЗДТГ-тай хамтран худалдаа эрхлэгчид, даавуун цаасан тор үйлдвэрлэгч иргэдтэй уулзалт хийж, БОАЖГ-аас хог хаягдлын менежмент ба гялгар уутнаас татгалзах талаар илтгэл, мэдээлэл хийлээ.

БОАЖЯ-ны дэд сайд Ц.Батбаяраар ахлуулсан ОБЕГ-ын гал түймэр унтраах хэлтэс, ЦЕГ, БОАЖЯ-ны ой хээрийн түймэр хариуцсан ахлах мэргэжилтэн оролцсон ажлын хэсэгтэй Тариалан, Эрдэнэбулган, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Түнэл сумдад ажиллаж Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймрийн идэвхтэй үеүдэд байнгын эргүүл, харуул, ажиллуулах, иргэдэд сургалт, сурталчилгаа хийх, сумын онцгой байдлын 1,2-р ээлжийн аврах бүлгүүдийг бэлэн байлгах талаар сумын удирдлагууд, төрийн албан хаагчид, иргэд, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлийн гишүүдтэй уулзалт хийж санал хүсэлт хүлээн авч хариу арга хэмжээг зохих ёсоор шийдвэрлэж ажиллалаа.

ХХААХҮЯ дээр ЖДҮ-ийн 2018 оны ажлын тайлан, 2019 оны төлөвлөгөө, хоршоог үнэлэх үнэлгээний аргачлалын сургалтад хамрагдаж, аймгийн Хөдөө аж ахуйн мэргэжилтний зөвлөгөөнд оролцогчдийг мэдээллээр хангасан.

Аймгийн МХГ-аас ирсэн албан бичгийн дагуу ажлын хэсэгт байгуулан аймгийн төвийн, орон нутгийн бүх засмал замд үзлэг шалгалт хийж үр дүнг Засан даргын зөвлөлийн хурлаар орууллаа. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу шаардлагатай зам засварлах болон замын тэмдэг тэмдэглэгээ хийх ажлын даалгавар болон зургийн даалгавар боловсруулав.

Хөвсгөл Дулааны станцын 2019 оны халаалтын жилээс шинээр хэрэглэгч нэмж холбох боломжгүй болсон тул ТЭЗҮ тооцоог хийлгэж эх үүсвэрийн өргөтгөлийг нэн даруй хийх шаардлагатай болсон талаар мөн Мөрөн сумын ундны эх үүсвэрийн худгууд, хэрэглэгч рүү ус шахах цэвэр усны 2-р өргөгч насос станцыг аваарын үед цахилгаан эрчим хүчээр хангахад нөөц дизель генератор шаардлагатай талаар тус тус Засаг даргын зөвлөлийн хуралд оруулсан байна.